

ӨГҮҮЛЭЛ

Япон Улсын Үндэсний аюулгүй байдлын стратегийн шинэ хандлага, төлөв

Баярсайханы Саранчимэг 

Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс
saranchimeg_b@mas.ac.mn

Хураангуй: Япон Улсын аюулгүй байдлын бодлогын үндсэн гурван баримт бичгийг шинэчлэн баталснаа 2022 оны 12 дугаар сард зарласан нь судлаачдын анхаарлыг ихээр татсан бөгөөд АНУ-Японы холбоотны харилцааг өөрчлөгдөх магадлалтай юу? Япон Улс цэрэг стратегийн хувьд бие даасан байдлыг эрмэлзэж байна уу? гэдэг асуултууд дагуулсан.

Тус өгүүлэлд уг баримт бичгүүдэд гарсан шинэ зүйл нь чухам юу вэ, аюулгүйн орчны сорилтууд нь уг баримт бичигт өөрчлөлт оруулах олон улсын нөхцөл байдлаас үүссэн субъектив хандлага мөн үү? Бодлогын шинэчлэл нь Японы үндэсний аюулгүй байдлыг хангаж чадах уу? гэсэн асуудлуудыг хөндөж байна. Энэ өгүүлэлээр шинээр батлагдсан АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратеги баримт бичиг, Япон-Америкийн аюулгүй байдлын гэрээ, Батлан хамгаалах бодлогын баримт бичиг, Үндэсний Аюулгүй Байдлын Стратегийн 10 жилийн хугацаанд хэрэгжиж ирсэн бодлого зэргийг нягтлан үзэж дүн шинжилгээ хийхийг зорьлоо.

Түлхүүр үгс: Япон Улс, Үндэсний Аюулгүй Байдлын Стратеги, Үндэсний батлан хамгаалах стратеги, Батлан хамгаалахыг бэхжүүлэх хөтөлбөр, Япон-Америкийн аюулгүй байдлын гэрээ



Удиртгал

Дэлхий нийтийг хамарсан ямар ч аюул заналаас аливаа улс орон ангид байж чадахгүй, нөгөөтэйгүүр дэлхий ертөнцөд аль ч улс дангаараа энх тайван, аюулгүй байдлаа хамгаалж чадахгүй. Тиймээс аливаа улсын үндэсний аюулгүй байдлын нөхцөл байдал нь нийлэн орших бүс нутаг, хөрш орнуудын улс төрийн өөрчлөлт, өрнөлт, улс хоорондын харилцаанаас шууд хамааралтай байдаг. Японы аюулгүй байдлын орчны өөрчлөлт асар хурдацтай өрнөж, хэдэн арван жилээр бус, жил, сар, өдрөөр хэмжигдэн, тэр хэмжээгээр аюулгүй байдлаа хамгаалах бодлогод өөрчлөлт шинэчлэл хийх шаардлага тулгарч байна.

2022 оны 12-р сарын 16-нд Фумио Кишидагийн засгийн газар Үндэсний Аюулгүй Байдлын Стратеги (国家安全保障戦略), Үндэсний батлан хамгаалах стратеги (国家防衛戦略), Батлан хамгаалахыг бэхжүүлэх хөтөлбөр (防衛力整備計画) гэсэн гурван шинэ стратегийн баримт бичгийг баталсан. Тэгвэл гурван баримт бичигт орсон шинэ зүйл юу вэ?

Үндэсний Аюулгүй Байдлын Стратеги (国家安全保障戦略) баримт бичиг анх 2013 онд батлагдсан. Уг баримт бичигт Хятад, Оросыг түнш орон, аюулгүй байдлын сорилт нь Хойд Солонгос гэж тодорхойлж байсан. Үүнээс хойш анхны шинэчилсэн найруулгыг 2022 оны 12 дугаар сард хийхдээ гол сорилтыг ① Хятад ② Орос ③ Хойд Солонгос¹ гэж эрэмбэлсэн нь өнгөрсөн хугацаанд геополитикийн орчин эрс өөрчлөгдөж, олон улсын

нөхцөл байдал таамаглашгүй хүндэрснийг тод харуулж байна.

Японы Үндэсний батлан хамгаалах стратеги (国家防衛戦略)-т батлан хамгаалах зардлыг ирэх 5 жилийн хугацаанд ДНБ-ний 2 % -д хүргэнэ гэж тусгажээ.

Батлан хамгаалахыг бэхжүүлэх хөтөлбөр (防衛力整備計画)-т батлан хамгаалах хүчээ бэхжүүлэхийн тулд эсрэг талд цохилт өгөх, хариу арга хэмжээ авах хүчин чадал бүхий техник хэрэгслийг нэмэгдүүлэхээр тодорхой заажээ.

Уг баримт бичгүүдэд өөрчлөлт оруулах нь олон улсын геополитикийн нөхцөл байдлаас үүссэн субъектив хандлага мөн үү? гэдгийг НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 77 -р чуулганд хэлсэн АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Байдений үг, 2022 оны 10 сард нийтлэгдсэн АНУ-ийн Үндэсний Аюулгүй Байдлын Стратегийг сөхөн харах нь Япон улсын үндэсний аюулгүй байдалд заналхийлэх бодит сорилт нь юу болох, БНХАУ болон ОХУ-ыг сорилт гэж үзэх шалтгаан, хүчин зүйлийг тодорхойлоход тус болох болов уу.

“Өнөөдөр бидний өмнө тулгараад байгаа сорилтууд асар том боловч бидний чадавхи түүнээс ч илүү юм. Бидний амлалтууд үүнээс ч илүү байх ёстой. Тиймээс бид нэгдмэл байдлаа дахин бататгацгаая. Дэлхий нийтээрээ НҮБ-ын үнэт зүйлсийг эрхэмлэдэг нэгдмэл хэвээр байна. Бид хамтран ажилласнаар бид түүхийн нумыг илүү эрх чөлөөтэй, илүү шударга ертөнц

¹ <https://www.cas.go.jp/jp/siryou/221216anzenhoshou/nss-c.pdf>

рүү эргүүлж чадна гэдэгт итгэж байна. Бидний хэн нь ч үүнд бүрэн хурч чадаагүй ч хойч үеийнхээ төлөө идэвхгүй гэрч биш түүхийн зохиогчид байх ёстой. Өнөөдөр бидний өмнө тулгараад байгаа сорилтууд үнэхээр том боловч бидний чадавхи үүнээс илүү.”² (НҮБ-ын Ерөнхий ассемблейн 77-р чуулган, АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Байден)

АНУ-ын ҮАБС-ийн баримт бичигт “БНХАУ бол олон улсын дэг журмыг өөрчлөх зорилготой цорын ганц өрсөлдөгч юм. Эдийн засаг, дипломат ажиллагаа, цэрэг, технологийн хүч улам бүр нэмэгдсээр байна. Энэтхэг-номхон далайн бүс нутагт нөлөөллийн хүрээг нэмэгдүүлж, дэлхийн гүрэн болох хүсэл эрмэлзлэлийн тэргүүлэгч хүч болоод байна. Технологийн хүчин чадлаа ашиглаж, нөлөөгөө улам бүр нэмэгдүүлсээр байна.”³ БНХАУ-д хандах бидний стратеги гурван талтай гэжээ. Үүнд:

1. Өрсөлдөх чадвар, инноваци, тэсвэр хатуужил, ардчиллын үндэс суурийг бэхжүүлэх
2. Нийтлэг зорилготой холбоотон болон түншүүдтэй хамтрах
3. Ирээдүйд эрх ашгаа хамгаалахын тулд БНХАУ-тай харуцлагатай өрсөлдөнө. БНХАУ-ыг давахын тулд зайлиггүй шаардлагатай салбар улс төр, эдийн засаг, технологи, цэрэг, тагнуулын салбарт өрсөлдөнө.”⁴

Мөн дээрх баримт бичигт ОХУ-ыг “Оросын засгийн газар сүүлийн 10 жилийн хугацаанд олон улсын дэг журмын гол элементүүдийг устгах зорилготой империалист гадаад бодлого явуулах сонголт хийсэн. Энэ нь эцэстээ Украины засгийн газрыг унагаж, хяналтандаа оруулахыг оролдсон бүрэн хэмжээний довтолгоо байсан. Гэхдээ энэ нь гэнэт гарч ирээгүй, үүний өмнө Орос 2014 онд Украин руу довтолж, Сирид цэргийн ажиллагаа явуулж, тагнуулын болон кибер чадавхийг ашиглан хөршүүдээ тогтворгүй болгох гэсэн олон жилийн оролдлого, Европ, Төв Ази болон дэлхийн улс орнуудын дотоод ардчиллын үйл явцыг алдагдуулах гэсэн хүчин чармайлт гэдэг нь илт байсан. Мөн ОХУ нь АНУ-ын улс төрд увайгүй оролцож, Америкийн ард түмний дунд хагарал, үүсгэхийн төлөө ажиллаж байна. Мөн ОХУ-ын эдгээр үйлдлүүд олон улсын тавцанд хязгаарлагдахгүй Оросын дотоод улс төр тогтворгүй болж байна. Ерөнхийлөгч Путины засаглал хүний эрхийг зөрчиж, сөрөг хүчнээ дарж, хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслийг хааснаар дотооддоо үймээн самуунтай байна. Ард түмнийхээ хэрэгцээ шаардлагад нийцдэггүй, зогсонги улс төрийн тогтолцоо бий болсон.”⁵ Украинд өрнөж буй дайнаас хамааралтай хэд хэдэн зүйл АНУ-ын бодлогын зарим асуудал болсон нь нэгэнт тодорхой болсон.

² National Security Strategy October 22, p 24, President Joseph R. Biden, JR 77th Session of the United Nations General Assembly ҮАБС, 10 сарын 22, НҮБ-ийн Ерөнхий Ассемблейн 77-р чуулганд АНУ-ын Ерөнхийлөгч Байдэний хэлсэн үг. <https://www.whitehouse.gov/wp-content/uploads/2022/10/Biden-Harris-Administrations-National-Security-Strategy-10.2022.pdf>

³ National Security Strategy October 22, The White House. Washington pp 23

⁴ National Security Strategy October 22, The White House. Washington pp 24

⁵ “National Security Strategy October 22” The White House. Washington 25-р тал

ОХУ-д хандах бидний стратеги:

1. АНУ Украиныг эрх чөлөөний төлөөх тэмцэлд үргэлжлүүлэн дэмжиж, Украиныг эдийн засгийн хувьд сэргээхэд нь тусалж, Европын холбоотой бүс нутгийн интеграциллыг дэмжих болно.
2. АНУ, НАТО-гийн нутаг дэвсгэрийн нэг сантиметрийг ч хамгаалж, Оросыг Европын аюулгүй байдал, ардчилал, институцид цаашид хохирол учруулахаас сэргийлэхийн тулд холбоотон болон түншүүдтэйгээ эвсэл байгуулж, гүнзгийрүүлэх болно.
3. АНУ, өөрийн орны үндсэн эрх ашигт заналхийлж буй Оросын үйлдлүүдийг, тэр дундаа манай дэд бүтэц, ардчилалд ОХУ-ын халдлагыг хориглож, шаардлагатай бол хариу өгөх болно.
4. Оросын ердийн арми суларч, Москвагийн цэргийн төлөвлөлтөд цөмийн зэвсгийн хамаарлыг нэмэгдүүлэх болно. Цөмийн зэвсэг ашиглах, заналхийлэх замаар зорилгодоо хүрэхийг АНУ зөвшөөрөхгүй.

Америк стратегийн тогтвортой байдлыг хадгалах, шинэ СТАРТ⁶-ыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд илүү өргөн хүрээтэй, ил тод, баталгаатай зэвсгийн хяналтын дэд бүтцийг хөгжүүлэх, Оросын үйл ажиллагааны улмаас эвдэрсэн Европын аюулгүй байдлын зохицуулалтыг сэргээх

сонирхолтой хэвээр байна. Эцэст нь, АНУ прагматик горимыг дэмжиж, хөгжүүлэх болно.”⁷

Дээрх баримт бичигт АНУ-ын манлайллын төлөөх өрсөлдөөнд Орос, Хятадын геополитикийн харилцан хамаарал гол сорилт болж байгааг тодорхой дурдсан байна. Энэ сорилтыг давахын тулд нийтлэг үнэт зүйлсийг эрхэмлэгч холбоотон болон түнш орнуудтай хамтарна гэдэг байр сууриа ч тодорхой илэрхийлсэн байна.

Ерөнхий сайд сайд асан Фүмио Кишида 2023 оны 1 дүгээр сарын 13-нд Вашингтоны Жонс Хопкинсийн их сургуулийн олон улсын ахисан түвшний судалгааны сургууль (SAIS) дээр тавьсан илтгэлдээ “2022 онд би Японы гадаад болон аюулгүй байдлын бодлогод хоёр том шийдвэр гаргасан. Нэг нь Украины эсрэг түрэмгийллийн хариуд Орос руу чиглэсэн бодлогоо өөрчилсөн явдал юм. Нөгөө нь өнгөрсөн оны сүүлчээр Үндэсний аюулгүй байдлын стратеги, Үндэсний батлан хамгаалах стратеги, Батлан хамгаалахын бэхжүүлэх хөтөлбөр гэсэн гурван үндсэн баримт бичгийг боловсруулснаар Японы дайны дараах аюулгүй байдлын бодлогод өөрчлөлт оруулсан явдал юм. Тэд хоёулаа Япон болон дэлхийн ирээдүйд нөлөөлсөн маш хүнд шийдвэрүүд байлаа. Эдгээр шийдвэр нь манай үндэстэн төдийгүй дэлхийн өнцөг булан бүрт зөв шийдвэр байсан гэдэгт би итгэж байна.”⁸ Эцэст нь хэлэхдээ “Олон улсын хамтын нийгэмлэг түүхэн эргэлтийн цэг дээр байгаа тул би улс орныхоо

⁶ “Шинэ СТАРТ” гэрээ нь Америкийн Нэгдсэн Улс, ОХУ-ын хооронд байгуулсан Стратегийн давшилтын зэвсгийг цаашид хорогдуулах, хязгаарлах арга хэмжээний тухай гэрээ.

⁷ “National Security Strategy October 22” The White House. Washington 26-р тал

⁸ <https://www.americanrhetoric.com/speeches/fumiokishidajohnshoptkins.htm>

өмнө тулгараад байгаа сорилтуудыг шийдвэрлэхийн тул дорвитой шийдвэр гаргасаар байх болно. Япон зоригтой урагшилж, АНУ-тай хамт бид түүхийн эргэлтийн цэгийг даван туулж, “Чөлөөт, нээлттэй Энэтхэг Номхон далай”-ыг бий болгоно.”⁹ хэмээн хэлсэн байна. Шинзо Абэ Японы Ерөнхий сайдаар 2006-2007 онд ажиллахдаа дөрвөн талт аюулгүй байдлын үзэл баримтлалыг эхлүүлж, Энэтхэг улстай нягт харилцаатай байхыг онцлон тэмдэглэсэн. Тэрээр 2007 онд энэтхэгт хийсэн айлчлалынхаа үеэр Энэтхэгийн парламентын гишүүдэд хандан “Хоёр тэнгисийн уулзвар”¹⁰ хэмээх илтгэлдээ “Энэтхэгийн нээлт” гэсэн үг бол бид Энэтхэгтэй ижил үнэт зүйл, ашиг сонирхлоо хуваалцдаг түнш мөн, бидэнтэй мөр зэрэгцэн хамтын ажиллагаагаа баяжуулах нөхөр гэдгээ дахин нээсэн гэсэн утгатай үг юм. Бүгдэд нээлттэй, ил тод байх эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн далай хийгээд “илүү өргөн Ази”-ийг дэмжихийн тулд Номхон далай болон Энэтхэгийн далайд нэгдэхийн чухлыг онцлон тэмдэглэж байв. Япон, Энэтхэг хоёр ингэж нэгдэн нийлснээр энэхүү “Өргөн Ази” нь Номхон далайг бүхэлд нь хамарсан, Америкийн Нэгдсэн Улс, Австрали улсыг багтаасан асар том сүлжээ болон хувирах болно. Шинэ газарзүй бий болно гэж төсөөлж, АНУ, Австрали, Энэтхэг улстай дөрвөн талт хамтын ажиллагааг улам ойртуулахыг уриалж байв. Чухамдаа энэ илтгэл нь Энэтхэг-Номхон далайн бүс нутгийг хэрхэн төсөөлж болох тухай тодорхой бүтцийг

олж нээсэн нь түүний тодорхойлсончлон “эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн далай мэт динамик холбоо” юм. “Чөлөөт, Нээлттэй Энэтхэг-Номхон далайн бүс нутаг” гэгддэг “эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн нум”-ыг сурталчилж, дөрвөлжингийн сүнс гэж тодорхойлсон стратегийг үргэлжлүүлэх нь Абэгийн гадаад бодлогын үндэс түүний “**өв**”-ийг залгалжлах нь Кишидагийн засаг захиргааны бас нэг онцлог шинж байсан бөгөөд Түншүүдтэй хамтран ажиллахад онцгой ач холбогдол өгч байгаа нь Абэгийн үед эхлүүлсэн санаачилгыг бодитой хэрэгжүүлж чадсан. Тэрээр 2022, 2023, 2024 онд НАТО-гийн удирдагчдын түвшний дээд хэмжээний уулзалтад оролцож, эвслийн Энэтхэг-Номхон далайн түншлэлийн бүлгийг хүлээн авч, “Өнөөдөр Украин маргааши Зүүн Ази байж магадгүй”, Украиныг дэмжиж, Европын түншүүдтэй ихээхэн хэмжээний оролцоотойгоор энэхүү үзэл баримтлалыг бэхжүүлэх хүсэлтэй байгаа нь илэрхийлж байсан. Абэгийн засаг захиргааны үед түншлэлийн гэрээ байгуулж, НАТО-д Японы төлөөлөгчийн газраа нээснээр албан ёсоор тогтсон Хойд Атлантын цэргийн эвсэл /НАТО/-тай Кишидагийн засгийн газар дээд түвшинд хүргэжээ.

Кишидагийн Украинд хийсэн айлчлалаар 2023 оны G7-г даргалах нь тодорхой болсон бөгөөд Дэлхийн 2-р дайны дараах дайны бүсэд очсон анхны айлчлал байсан бөгөөд Японы идэвхтэй, зоримог удирдагч болохоо харуулсан. G7-ын удирдагчийн бүрэн эрхийн хугацаагаа ашиглан, дэлхийн

⁹ <https://www.americanrhetoric.com/speeches/fumiokishidajohnshopkins.htm>

¹⁰ <https://worldjpn.net/documents/indices/FOIP/index-ENG.html>

өмнөд хэсэгт Хятад, Оросын нөлөөг эсэргүүцэх үүднээс бүс нутгийн түншүүдийг бүлгийн хуралдаанд оролцуулсан. Хирошимад болсон тус хуралдаанд Өмнөд Солонгос, Австрали, Комор, Күүкийн арлууд, Энэтхэг, Индонез, Вьетнам, БРИКС-ийн удирдагч Бразилийн улсууд оролцсон байна.

Япон-АНУ-ын холбоог гүнзгийрүүлэх, Япон-АНУ-ын эвслийг бэхжүүлэх нь нутаг дэвсгэрийн батлан хамгаалах, бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг хангах чухал элемент гэж хүлээн зөвшөөрөгдсөн хэвээр байна. Япон өмнө нь зөвхөн АНУ-тай харилцан нэвтрэх гэрээтэй байсан энэ статусыг тэлж гэрээнд гарын үсэг зурсан.

Харилцан нэвтрэх гэрээ (Reciprocal Access Agreement – RAA).

2022 оны 1-р сарын 6-нд Ерөнхий сайд Фумио Кишида, Ерөнхий сайд Скотт Моррисон нар онлайнаар дээд хэмжээний уулзалт хийж Австрали-Японы тусгай стратегийн түншлэл байгуулагдсан юм. Australia-Japan Reciprocal Access Agreement (RAA) буюу Харилцан нэвтрэх хэлэлцээрт гарын үсэг зурсан явдал олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр “цэргийн холбоо” “батлан хамгаалах гэрээ” хэмээн шуугисан ч үүнд Сиднейн их сургуулийн ахлах багш, Австралийн стратегийн бодлогын хүрээлэнгийн (ASPI) ахлах ажилтан Томас Вилкинс [国際情報ネットワーク分析 IINA](#) сайтад тайлбар бичсэн. RAA батлан хамгаалах, цэргийн хамтын ажиллагааг хамардаг ч ийм тайлбар нь огт буруу юм. Цэргийн эвсэл, батлан хамгаалах гэрээ нь албан ёсны гэрээний баримт бичигт

үндэслэсэн бөгөөд гэрээлэгч талууд бие биедээ цэргийн дэмжлэг үзүүлэх үүргийг хуулийн дагуу хүлээдэг. Үүнд тулалдаанд болон тодорхой нөхцөл байдалд хүч хэрэглэх (Конвенцид заасан үндэслэл) багтана. Гэсэн хэдий ч, ийм агуулга нь RAA-д заагаагүй тул шинжээчдийн тайлбар нь “эвсэл” бий болсон гэсэн үг биш юм.

Харин гэрээ нь бие биенийхээ бааз, боомтод харилцан нэвтрэх боломжийг хөнгөвчлөх хууль эрх зүй, ложистик, аюулгүй байдлын тогтолцоог ихээхэн тогтоож өгсөн. Тиймээс Япон, Австралийн цэргийн албан хаагчид, энгийн иргэд, цэргийн эд хөрөнгө (тоног төхөөрөмж гэх мэт)-ийг нөгөө улсын нутаг дэвсгэрт байрлуулах бодит журмыг заасан байдаг.

Одоогоор АНУ-ын ойрын холбоотон дараах орнууд цэргийн сургалт, хамтарсан бэлтгэл, ажиллагаа дэмжих, хангалт хийх зэрэг зорилгоор харилцан цэрэг зорчин байршуулах гэрээнүүд байгуулаад байна.

Япон – Их Британи (2023 онд RAA байгуулсан)

Япон – Австрали (2022 онд RAA байгуулсан)

Япон – Франц (2023 онд RAA байгуулах замын зураг зарласан)

Япон – Филиппин (2024 онд RAA байгуулахаар бэлтгэж байна)

Австрали – Франц (2023 онд RAA байгуулсан)

БНСУ – Их Британи (2023 онд RAA байгуулахаар хэлэлцээ эхлүүлсэн)

БНХАУ-ын тэлэлтийг тэнгист тогтоон барихын тулд АНУ сүүлийн жилүүдэд хоёр талт холбоотны гэрээнүүдээ шинэчлэн бэхжүүлэхийн хамт олон талт түншлэлийн форматууд

санаачлан хөгжүүлж өөр бусад бүс нутгаас холбоотон, түншүүдээ Энэтхэг-Номхон далайн аюулгүй байдлын архитектурт татан оролцуулж эхлээд байна. Эдгээр гишүүн орнууд ардчилсан, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх үнэт зүйлсээрээ нийтлэг улсууд юм. Онцлох зарим форматуудаас дурдвал:¹¹

QUAD. АНУ, Австрали, Япон, Энэтхэгийн түншлэлийн QUAD формат нь шууд цэргийн эвсэл биш боловч улс төр, эдийн засаг, технологийн салбарын бодлогын уялдаа холбоо, координацаар дамжуулан БНХАУ-ын эсрэг нэгдсэн шугам үүсгэх оролдлого юм.

AUKUS. АНУ, Австрали, Их Британий цэргийн нарийн технологи хуваалцах гэрээ. Гол зорилго нь Австралийг цөмийн шумбагчийн бүрэн флоттой болгох замаар Энэтхэг-Номхон далай дахь Хятадын тэнгисийн хүчний эсрэг тэнцвэр барих зорилготой. AUKUS-I нь цөмийн шумбагч хөлгийн технологи бол AUKUS-II нь өөрөө явагч байлдааны систем, дрон, робот, хиймэл оюун, кибер ба сансрын технологи хуваалцах гэрээ болно. AUKUS-т хэсэгчлэн нэгдэх талаар Япон, Канад, Шинэ-Зеланд улсууд сонирхлоо илэрхийлж буй бөгөөд хэрвээ оролцсон тохиолдолд Хятадын эсрэг зорилготой цэргийн технологийн формат руу орж буй хэрэг болно.

Умард Азийн гурвал. 2023 он нь АНУ, Япон, БНСУ-ын хувьд харилцаагаа ойртуулж гурвалсан форматаар бүс нутгийн асуудлуудад нэгдсэн координац хийх “Кэмп Дэвидийн уулзалт” хийсэн чухал жил болсон. Ялангуяа Япон,

БНСУ хоорондын түүхэн асуудлуудаа өнгөрсөнд үлдээж одоо ба ирээдүйн тулгарч буй сорилтуудад (БНАСАУ, БНХАУ, ОХУ) АНУ-ын хамтаар сөрөн зогсох түүхэн шийдэлд хүрсэн нь онцгой явдал байлаа.

Аюулгүй байдлын баримт бичигт Орос, Хятадыг сорилт гэж үзэх шалтгаан АНУ-ын холбоотон гүрний хувьд ижил үүрэг хүлээх зайлшгүй шаардлага бий болжээ гэж үзэх үндэстэй байна. Японы аюулгүй байдлын бодлогын уламжлалт шинж чанар нь Япон-Америкийн аюулгүй байдлын гэрээнд оршдог. Япон-АНУ-ын аюулгүй байдлын гэрээний 5-р зүйл¹²д үндэслэн Японы эсрэг зэвсэгт халдлага үйлдсэн тохиолдолд Япон, АНУ хоёр талын арга хэмжээ авах ба Япон улс нь АНУ-ын цэргийн хүчинд зориулан байгууламж, бүс нутгийг 6-р зүйлд үндэслэн олгоно. Хэрэв аль нэг улс Япон руу довтлохоор төлөвлөж байгаа бол халдагч этгээд зөвхөн Өөрийгөө Хамгаалах Хүчний (SDF) хамгаалалтын чадавхийг төдийгүй АНУ-ын Японыг хамгаалах үүрэг хүлээсний улмаас АНУ-ын асар их цэргийн хүч чадлыг даван туулахад бэлэн байх ёстой.

1947 онд батлагдсан Японы Үндсэн хуулийн 9 дүгээр заалтад “Япон нь газар, тэнгис, агаарын аливаа зэвсэгт хүчтэй байхгүй, мөн дайн хийх бүрэн эрхээс татгалзана”¹³ гэж заасан байдаг. Энэ нь Японы аюулгүй байдлаа хамгаалах буюу өөрийгөө бие даан хамгаалах эрхэд харшилж байна гэж үзэж, Шинзо Абэ асаны Засгийн газар үндсэн хуулийн 9 дүгээр заалтыг

¹¹ <https://niss.gov.mn/archives/3746>

¹²

¹³ 日本国憲法第九条 (Япон улсын үндсэн хуулийн 9-р заалт)

шинэчлэх тал дээр шургуу ажиллаж, үндсэн хуульд үг үсгийн засвар хийж, Япон Улсын армитай байх эрхийг албан ёсоор баталгаажуулахыг хүсэж байгаагаа Абэ асан Үндсэн хууль батлагдсаны 70 жилийн ойгоор буюу 2017 оны 5-р сарын 3-нд Шинзо Абэ асан тодорхой хэлсэн байдаг. “Манай улс аюулгүй байдлаа хамгаалахад үндсэн хуулийн 9 дүгээр зүйл харшилж байна, бид үндсэн хуулийн 9 дүгээр заалтыг өөрчлөхгүйгээр юу ч хийж чадахгүй. 2020 он бол шинэ Үндсэн хуулийн жил болно гэдэгт найдаж байна. Ард түмэн та бүгдийнхээ итгэл найдварыг хөсөрдүүлэлгүй, Үндэсний эрх ашгаа хамгаалж, энх тайван, тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтийн төлөө хамтдаа алхана ”¹⁴

Үндсэн хуулийн 9-р заалтад өөрчлөлт оруулах эрх зүйн орчинг бүрдүүлэхийн тулд ,

2013 оны 12 сарын 4-нд “Үндэсний Аюулгүй Байдлын зөвлөл”¹⁵ байгуулж, 12 сарын 17-нд “Үндэсний Аюулгүй Байдлын Стратеги”, Үндэсний батлан хамгаалах хөтөлбөр, Батлан хамгаалах бодлогын дунд хугацааны хөтөлбөрийг тус тус боловсруулсан явдал нь шинэчлэлийн суурь тавигдсан гэж үздэг ч үндсэн хуулийн хэлэлцүүлэг тийм ч үр дүнтэй байгаагүй. Үндсэн хуулийг өөрчлөх саналыг парламентийн дээд ба доод танхимын аль алиных нь гуравны хоёроос дээш хувь дэмжих ёстой. Ингэж чадвал бүх нийтийн санал асуулга явуулах эрхтэй болно. Санал асуулгаар ердийн олонх дэмжвэл

хуульд оруулах өөрчлөлт дэмжигдсэнд тооцогдоно. Зөвхөн албан ёсны армитай байх боломжийг нээх гэсэн оролдлого гэж үздэг. Үүнээс өмнө Шинзо Абэ Өөрийгөө Хамгаалах Хүчин (SDF)-ийг зарим тохиолдолд холбоотнуудтай хамт дайнд орох боломжийг нээх тухай ярьж байсан нь ихээхэн маргаан дагуулсан юм. Японы олон нийт энэ асуудлаар хуваагдмал байр суурьтай байдаг. Хэдийгээр Хойд Солонгосын аюул нэмэгдэж, Хятадтай маргаан үргэлжилж байгаа ч ард иргэдийн ихэнх нь үндсэн хуулийг өөрчлөх хэрэггүй гэж үзэж байгаа санал асуулгаар иргэдийн 35 хувь нь Абэгийн саналыг дэмжиж, 42 хувь нь эсэргүүцсэн байдаг. Нийгэм, эдийн засгийн асуудал нэгдүгээрт тавигдах ёстой гэж олонх нь үзсэн хэвээр байсан юм. Энэ хоёр тохиолдолд дотоодын маргаантай асуудал нь Япон улс үндсэн хуулийн тайлбарт үндэслэн өмнө нь хүлээн зөвшөөрөөгүй байсан хамтын өөрийгөө хамгаалах эрхээ хэр зэрэг хэрэгжүүлж чадах вэ гэдэг сорилт байсан.

Үндэсний аюулгүй байдлын стратеги анх 2013 онд боловсруулагдах хүртлээ батлан хамгаалах бодлогын үндэс суурь хэрхэн тавигдаж, өөрийгөө хамгаалах хүчин хязгаарлагдмал байгаагаас батлах хамгаалах чадавхийг бэхжүүлэх хууль эрх зүйн орныг бүрэлдүүлэхэд ямар сорилт бэрхшээлийг даван туулж ирснийг дурдах нь зүйтэй.

1990-ээд онд Хойд Солонгос цөмийн зэвсэг болон баллистик пуужин хөгжүүлсний хариуд 1999 онд

¹⁴ 憲法改正に関する首相メッセージ全文
T00C17A5000000/

https://www.nikkei.com/article/DGXLASF03H16_

¹⁵ Үндсэн хуулийг засварлах талаар Ерөнхий сайдын хэлсэн үг

батлагдсан Японы эргэн тойрон дахь бүс нутгуудын онцгой байдлын тухай хууль (Шүхэнжитай-хо) нь Солонгосын хойгт гэнэтийн аюул ослын тухай тусгасан бөгөөд томоохон үйл явдал болсон юм.

2015 оны Энх тайван, аюулгүй байдлын тухай хууль тогтоомж (Хэйва анзэн-хо) байсан бөгөөд энэ нь Японы аюулгүй байдалд чухал нөлөө үзүүлж болзошгүй захын гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд хамтын өөрийгөө хамгаалах эрхийг хэсэгчлэн зөвшөөрсөн хууль эрх зүйн хувьд эргэлт гарсан томоохон ахиц байсан юм. Япон улс олон улсын аюулгүй байдлын орчны өөрчлөлттэй холбогдуулан Үндэсний аюулгүй байдлын бодлогоо өөрчлөхийг оролдсон анхны тохиолдол биш гэж үзэх үндэс ч бий болж байна.

Харин Япон Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь Японы газар нутагт аюул учирч болзошгүй гэсэн таамаглалд үндэслэн боловсруулсан стратеги юм. Япон Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл байгуулагдсанаас хойш Аюулгүй байдлын хууль эрх зүйн зохицуулалт, аюулгүй байдлын эрхзүйн үндсийг бүтцийн хувьд өөрчлөх тухай, Өөрийгөө хамгаалах хүчний тухай хууль тогтоомжийг шинэчлэх тухай, олон улсын энхтайвны хамтын ажиллагаанд нэгдэхэд Япон улс бусад оронд цэргийн хамтарсан үйл ажиллагаа явуулах тухай хууль, тэнгисийг хамгаалах үйл

ажиллагааг түргэвчлэх, Хойд солонгосын цөмийн хөтөлбөр, пуужингийн довтолгооноос хамгаалах шинэ системийг хөгжүүлж, довтолгооноос хамгаалах чадавхыг сайжруулах зэрэг асуудлыг хөндөж 300-аад удаа аюулгүй байдлын асуудлаар зөвлөгөөн явагдсан. 2015 оны Энхтайван, аюулгүй байдлын тухай хууль тогтоомж нь засгийн газрын үндсэн хуулийн тайлбарыг өөрчилж, Японд хамтын өөрийгөө хамгаалах эрхээ хэсэгчлэн хэрэгжүүлэх боломжийг олгож, улмаар АНУ-тай хамтран ажиллах хүрээг өргөжүүлж, онцгой байдлын төлөвлөлт хийх илүү боломжийг бий болгосон. Уг хууль тогтоомжийг харгалзан, Кишидагийн засаг захиргаа батлан хамгаалахын төсвийг таван жилийн дотор ДНБ-ий 2 хувьд хүргэхээр зорьж, 2022 оны 2-р сарын 14-ний өдөр Либерал Ардчилсан нам (LDP)-ийн Аюулгүй байдлын бодлогын судалгааны зөвлөлд болсон сонголт дээр тодорхой тохиолдлуудыг харгалзан довтолгооны эсрэг чадавхи шаардлагатай гэж санал болгов.

Үндэсний Аюулгүй Байдлын Стратеги¹⁶ нь Японы үндэсний эрх ашигт тулгуурлан боловсруулагдсан байна. *“Японы энх тайван, аюулгүй байдлыг хангаж, түүний оршин тогтнох хүчин зүйлийг бий болгох, Япон улс болон ард түмний цаашдын хөгжил цэцэглэлтэд хүрэхийн тулд илүү хүчирхэг энх тайван, аюулгүй байдлыг хангах ёстой, Нийтлэг*

¹⁶ 1976 онд хамгийн анх Японы батлан хамгаалахын үндсэн бодлого, батлан хамгаалах чадавхийн ач холбогдол, үүрэг, батлан хамгаалах чадавхийн цаашдын чиг хандлагыг тодорхойлсон, батлан хамгаалах зэвсэг, хэрэгсэл авах талаар тусгаж боловсруулагджээ. Тус хөтөлбөр 1995, 2004, 2010 онуудад Олон улсын терроризм, үй олноор хөнөөх зэвсэг, баллистик пуужингийн тархалт зэрэг олон улсын хамтын нийгэмлэгийн нийтлэг асуудлууд нэмэгдэж байгаатай холбогдуулан шинэчилсэн. Үндэсний батлан хамгаалах хөтөлбөрийг үндэслэн 2013 онд Үндэсний аюулгүй байдлын анхны стратеги боловсруулагдаж 2022 онд анх удаа шинэчлэн найруулсан.

“Хүснэгт 1. Япон Улсын Үндэсний аюулгүй байдалд тулгамдаж буй гол асуудлуудыг эрэмбэлэх нь

Огноо	Хойд солонгосын талаар	Украин асуудлын талаар	Зүүн Азийн нөхцөл байдлын талаар	Ази, Номхон далай	Энэтхэг, номхон далай	Өмнөд суданы асуудал	Европын нөхцөл байдал	Синайн хойг	Сансар отгоргүй аюулгүй байдал
2013						1			
2014	1	6	4	2		1	1		1
2015			2	4		2			
2016	14		2	4		5			1
2017	25		4		2	1	1		
2018			1		1	2			
2019	5		1		2	1		2	
2020	3				1	1		1	
2021	4					1	1	1	
2022	6	5	2			1		1	
2023	3					1		1	1
2024	1		1			2			

Эх сурвалж: “The World and Japan” Database

үнэт зүйл, дүрэмд захирагдаж, олон улсын дэг журмыг сахин хамгаалах”¹⁷ хэмээн тусгав.

Үндэсний Аюулгүй Байдлын Стратегийн зорилт¹⁸

1. Японы батлан хамгаалах чадавхийг сайжруулах, үүрэг оролцоог нэмэгдүүлэх, батлах хамгаалах салбарын үйл ажиллагааг тэлэх
2. Япон- Америкийн хамтарсан тунхаглалыг бэхжүүлэх
3. Олон улсын хамтын нийгэмлэгийн энх тайван, тогтвортой байдлыг хангахын тулд түншлэл болон аюулгүй байдлын хамтын ажиллагааг бэхжүүлэх
4. Олон улсын хамтын нийгэмлэгийн энх тайван тогтвортой байдлын төлөөх олон улсын хүчин чармайлтанд идэвхитэй хувь нэмрээ оруулах
5. Дэлхийн хэмжээний асуудлыг

шийдэхийн төлөө нийтлэг үнэт зүйлсийн дагуу хамтын ажиллагаагаа бэхжүүлэх

6. Үндэсний аюулгүй байдлыг дэмжих үндсэн нөхцлийг бэхжүүлж, дотоод гадаад дахь харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэх заажээ.

Япон Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Стратегийн зорилтуудын онцлох зүйл бол Японы өөрийн батлан хамгаалах чадавхийг бэхжүүлэх явдал юм.

Энэ утгаараа 2013-2024 онуудад Японы Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн аюулгүй байдлын асууддаар хэлэлцсэн гол гол асуудлуудаас Япон улсын хувьд гол аюул занал юу вэ гэдгийг дараах хүснэгтээс харж болох юм.

2016-2017 онд Хойд Солонгос 3 удаа цөмийн туршилт хийж, 40 гаруй баллистик пуужин хөөргөж, тухайн

¹⁷ https://www.cas.go.jp/jp/siryou/221216anzenhoshou/hosyousennryaku_gaiyou.pdf

¹⁸ https://www.cas.go.jp/jp/siryou/221216anzenhoshou/hosyousennryaku_gaiyou.pdf

жилдээ Хойд Солонгосын цөмийн туршилтын асуудлаар 14 удаа хэлэлцсэн байна. 2017 оны сүүлийн хагаст алсын тусгалын баллистик пуужингууд, тэр дундаа шинэ төрлийн пуужингуудыг удаа дараа хөөргөсөн нь 2017-2018 онд 25 удаа Солонгосын цөмийн туршилтын асуудлаар эрчимтэй хэлэлцсэн нь дээрх хүснэгтэд тодорхой харагдаж байна. 2019 оны 5-р сараас эхлэн тогтмол бус чиглэлтэй, нам өндөрт нисэх чадвартай, ойрын тусгалтай баллистик пуужингийн шинэ төрлийг дахин дахин хөөргөсөн. 2021 оны 9-р сараас эхлэн “гиперсоник пуужин” гэж нэрлэсэн пуужингаа дараалан хөөргөсөн ба шинэ төрлийн шумбагч онгоцноос харвах баллистик пуужин (SLBM) хэмээн таамаглаж байна. 2022 оноос хойш Хойд Солонгос урьд өмнө байгаагүй өндөр давтамжтайгаар пуужин харваж, тэр дундаа ICBM ангиллын баллистик пуужингуудыг нэг талт байдлаар хөөргөсөн нь Японы үндэсний аюулгүй байдлын зөвлөл олон улсын хамтын нийгэмлэгийн эсрэг өдөөн хатгалга гэж үзсэн.

Үүнээс улбаалаад батлан хамгаалахын бүтээн байгуулалтын гол асуудлуудыг хэлэлцсэнээр Батлан хамгаалах техник хэрэгслийг зөөн тээвэрлэх 3 зарчим, 2014-2018 онд 13 удаа, Батлан хамгаалах техник хэрэгслийг зөөн тээвэрлэх 3 зарчмын үйл ажиллагааны удирдамж 2019-2023 хугацаанд 5 удаа, Батлан хамгаалах техник хэрэгслийг зөөн тээвэрлэх

гурван зарчмын удирдамжийн хэрэгжилт, Үндэсний батлан хамгаалах хөтөлбөрийн удирдамж боловсруулагджээ. 2014-2016 хүртэл Ази номхон далайн нөхцөл байдлын талаар аюулгүй асуудал хэлэлцэж, 2019 оноос Энэтхэг-Номхон далайн аюулгүй байдлын асуудлаар хэлэлцэж эхэлсэн. Хойд Солонгосын асуудлаар нийт 62 удаа, Украйны асуудлаар 11 удаа, Зүүн азийн талаар 16 удаа, Ази номхон далай 10, Энэтхэг номхон далайн талаар 6 удаа тус тус хэлэлцжээ. 2019 оноос энэхүү аюул заналхийлэлд хэрхэн хариу арга хэмжээ авах талаар эрчимтэй хэлэлцэж эхэлсэн нь Хойд Солонгос Япон нутаг дэвсгэрт аюул учруулж болзошгүй бодит сорилт гэдгийг дахин баталж байна.

1992 онд НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаа болон бусад үйл ажиллагаатай хамтран ажиллах тухай хууль батлагдан, 2007 онд Батлан хамгаалах агентлагийг Батлан хамгаалах яам болгон өөрчилсөн. 2018 онд Батлан хамгаалах хөтөлбөрийг шинэчилж “Үндэсний батлан хамгаалах стратеги”-ийг боловсруулсан. Үндсэндээ энэ нь Батлан хамгаалах хөтөлбөрийн шинэчилсэн хувилбар. Энэ хөтөлбөрт Япон улс өөрийн аюулгүй байдлын үүднээс ямар төрлийн чадавхийг шаарддаг, батлан хамгаалын бэхжүүлэх хөтөлбөр эдгээрийг хангахын тулд ирэх таван жилд шаардагдах тоног төхөөрөмж, зардлыг тусгадаг гэсэн үг.

Хүснэгт 2. Батлан хамгаалахыг бэхжүүлэх хөтөлбөр болон дунд хугацааны батлан хамгаалах бүтээн байгуулалтын төлөвлөгөөний зардал

Үндэсний батлан хамгаалах хөтөлбөрийн удирдамж	Дунд хугацааны Батлан хамгаалах	Батлан хамгаалахын Засгийн газрын шийдвэрийн огноо	Батлан хамгаалахтай холбоотой таван жилийн зардлын дээд хязгаар
1976	1986	1985.9.18	18.4 их наяд иен
	1991	1990.12.20	22.75 их наяд иен
	1991	1992.12.18	22.17 их наяд иен
1995	1996	1995.12.15	25.15 их наяд иен
	1996	1997.12.19	24.23 их наяд иен
	2001	2000.12.15	25.1 их наяд иен
2004	2005	2004.12.10	24.24 их наяд иен
	2005	2008.12.20	24.64 их наяд иен
2010	2011	2010.12.17	23.39 их наяд иен
2013	2014	2013.12.17	24.67 их наяд иен
2018	2019	2018.12.18	27.47 их наяд иен
Үндэсний Аюулгүй Байдлын Стратеги	Батлан хамгаалахын төлөвлөгөө	Батлан хамгаалахын салбарын бүтээн байгуулалтын төлөвлөгөөний тухай засгийн газрын шийдвэрийн огноо	Батлан хамгаалахтай холбоотой таван жилийн зардлын дээд хязгаар
2022 оны Батлан хамгаалахын үндэсний стратеги	2023 оны Батлан хамгаалахын салбарын бүтээн байгуулалтын төлөвлөгөөний	2022.12.16	43 их наяд иен

Эх сурвалж: https://www.mod.go.jp/en/d_act/d_budget/index.html

Японы батлан хамгаалах бодлогын баримт бичгүүд хэд хэдэн удаа шинэчлэгдэхдээ батлан хамгаалах чадавхийг бэхжүүлэх талаар гол төлөв тусгагдаж байсан цэрэг стратегийн хувьд бие даасан байр суурьтай

байхыг эрмэлзэж байж магадгүй гэсэн таамаглалд ч хүрч байна. Өөрөөр өрийгөө эрс өөрчлөлт гэхээсээ илүү тогтвортой ахиц дэвшил гаргасан дүр зураг ажиглагдаж байна.

Дүгнэлт

Японы энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад бүх төрлийн зэвсэгт халдлага, тэр дундаа цөмийн зэвсэг ашиглах, цэргийн хүчээр дарамтлах, айлган сүрдүүлэх зэрэг гэнэтийн нөхцөл байдалд хариу үйлдэл үзүүлэх хүчирхэг хамгаалалтын системийг эрэлхийлж байна.

Украины эсрэг Оросын түрэмгийлэл нь олон улсын дэг журмыг бүрдүүлдэг дүрмийг зөрчиж, БНХАУ-ын зүүн тэнгисийн усан болон агаарын орон зайн статус-кво-г дангаар өөрчлөх оролдлого хийх зэргээр цэргийн үйл ажиллагаагаа өргөжүүлж байгаа нь Аюулгүй байдлын баримт бичгүүдэд Японы хувьд ОХУ, БНХАУ-ыг сорилт гэж авч үзэх нь үндсэн шалтгаан биш АНУ-ын гол сорилт болж түүнийг хязгаарлах, тогтоон барихад зайлшгүй АНУ-ын холбоотон гүрнүүдийн үүрэг роль нэмэгдэж байгаа нь гол шалтгаан юм. АНУ-ын гадаад бодлогын гол номлол “Тогтоон барих” үзэл баримтлалын дор Япон-АНУ-ын эвслийг бэхжүүлснээр нутаг дэвсгэрийн батлан хамгаалах, бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг хангаж чадна. Япон Улс ардчилал, хүний эрхийг дээдлэх, хууль дээдлэх, капиталист эдийн засаг зэрэг үндсэн үнэт зүйлсийг хуваалцдаг дэлхийн цэргийн хүчирхэг гүрэн АНУ-тай байгуулсан

Япон- Америкийн аюулгүйн гэрээг чандлан сахиж, хамтын ажиллагааны удирдамжийг даган мөрдөх нь аюулгүй байдлын үндэс суурь юм.

Хойд Солонгосын цөмийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаагай холбоотойгоор Японы нутаг дэвсгэрт аюул занал учруулж болзошгүй гол сорилт гэдэг нь ҮАБЗ-ийн хуралдаанаар батлагджээ. Япон Улс стратегийн гурван баримт бичгийг шинэчлэн найруулснаар нь өнгөрсөн 30 жилийн хугацаанд аюулгүй байдлын бодлогодоо бодитой алхам хийсэн түүхэн эргэлт болсон. Японы өөрийгөө хамгаалах чадварыг сайжруулж, өөрийгөө хамгаалах хүчээ шинэчилж, АНУ-Японы эвслийн үйл ажиллагааг бэхжүүлэхийн тулд АНУ-ын хүчинтэй хамтран ажиллах чадварыг нэмэгдүүлж байгаа нь энх тайванч гэх тодотголтой ч япон улс геополитикийн орчны өөрчлөлтөд батлан хамгаалах бодлогоо өргөтгөх амбицаа амжилттай хэрэгжүүлж байгаа чухал алхам болсон гэж үзэж байна.

2027 он гэхэд Японы батлан хамгаалах зардлаа ДНБ-ий 2% -иар тогтоосон түүхэн өсөлтийг хуульчилсан нь батлан хамгаалахын төсөв бүрдүүлэх, татварын дарамт гээд дотоодын эсэргүүцэлтэй нүүр тулж сорилт бэрхшээл үүсэх нь дамжиггүй.

Ном зүй / References:

Хууль, тогтоомж

1. Legislation for Peace and Security <https://www.mofa.go.jp/files/000143304.pdf>
2. Article 9 of the Japanese Constitution

Баримт бичгүүд

1. “National Security Strategy October 22” The White House. Washington. <https://www.whitehouse.gov/wp-content/uploads/2022/10/>
2. National Security Strategy <https://www.cas.go.jp/jp/siryoku/221216anzenhoshou/nss-e.pdf>
3. National Defense Strategy <https://www.mofa.go.jp/files/100590829.pdf>
4. National Defense Strategy <https://www.mofa.go.jp/files/100590829.pdf>
5. Japan-U.S Security Treaty https://www.mofa.go.jp/na/st/page1we_000093.html

Тайлан, мэдээ

1. 朝鮮半島問題の地政学的分析と我が国の対応” Institute for International policy studies /Солонгосын хойгийн асуудлын талаарх геополитийн дүн шинжилгээ ба манай улсын хариу арга хэмжээ / Олон улсын улс төр судлалын хүрээлэнгийн тайлан
2. 外交・安全保障関係シンクタンクのあり方に関する有識者懇談会報告書./Гадаад бодлого, аюулгүй байдлын харилцааны талаарх шинжээчдийн хэлэлцүүлгийн тайлан/ 2012 оны 8 сар
3. https://www.mod.go.jp/j/policy/agenda/guideline/pdf/security_strategy.pdf
4. <https://www.cas.go.jp/jp/siryoku/221216anzenhoshou/nss-e.pdf>
1. 国際情報ネットワーク分析 IINA https://www.mod.go.jp/en/d_act/d_budget/index.html
2. “The World and Japan” Database

Нэгэн сэдэвт бүтээл

1. Хантингтон.С *Иргэнийл хоорондын мөргөлдөөн: Шинэчлэгдэн буй дэлхийн шинэ дэг журам*. УБ., 2018
2. Hans Morgenthau. *Politics Among Nations: The Struggle for Power and Peace*. 7th edition. N.Y.: 2007
3. *Аюулгүй байдлын тулгуур асуудлууд*. Японы Үндсний батлан хамгаалах академи.УБ., 2016 он

Судалгааны өгүүлүүд

1. Гүнчин-Иш Х. “Япон Улсын батлан хамгаалах бодлогын цогц шинэчлэлийн тухай”. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал. 2023№36 (46)
2. Монгол Улсын Аюулгүй байдал: Онол, аргазүй, орчны шинжилгээ. БХЭШХ. УБ., 2019

3. Уламбаяр. Д «Аюулгүй байдлын уламжлалт ба орчин үеийн үзэл баримтлалын шинэ чиг хандлага»-Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ. УБ., 2014
4. Батбаяр Ц. Алс дорнод дахь АНУ-ын “түншлэх бодлого” Дорнодахины асуудал 1983 № 1(8)
5. Япон Улс - Америкийн Нэгдсэн Улсын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны удирдамж. Стратегийн судалгаа (2/2015) №70
6. Абэгийн загвар. *Японы аюулгүй байдлын шинэ бодлого*. Такаши Каваками. Стратегийн судалгаа, (3/2015) №71
7. Оюунгэрэл Л. *АНУ- Японы цэргийн түншлэлийн гол зорилго* “Дорнодахины асуудал, 1985 N°2 (13)

New Trends and Prospects of Japan's National Security Strategy

Saranchimeg Bayarsaikhan

Institute of International Studies, Mongolian Academy of Sciences

Ulaanbaatar, Mongolia

saranchimeg_b@mas.ac.mn

Abstract: *Japan's announcement in December 2022 that it will revise its three main security policy documents has attracted the attention of global researchers and has become a major geopolitical topic, raising questions about the possibility of a change in the US-Japan alliance or a break with tradition. This speech examines what is new in the documents, whether the challenges of the security environment are subjective attitudes arising from the international context that will change the document, whether policy reforms can ensure Japan's national security or Japan's strategic military independence. It raised the issues of whether it is striving, taking into account the National Security Strategy (USNSS) document, the Japan-US security agreement, the Defense Policy document that has been the priority of Japan's foreign policy until now, and the National Security Strategy (NSS) that has been implemented for 10 years. I intend to do a thorough analysis.*

Keywords: *National Security Strategy, National Defense Strategy, Defense Buildup Program, Japan-US Security Treaty*

The day of submission: 2024.10.02

Completion of Review: 2024.11.25

Final decision for acceptance: 2024.12.27